

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2021 оны 12 дугаар сарын 30

Дугаар 2.021/35

Баянлиг сум

Нэг. Удиртгал хэсэг

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Хатан суудал 5-р багийн нутаг дэвсгэрт баригдсан бага төвөгшилтэй ангиллын 240 хүний суудалтай 2 давхар хүчин чадал бүхий Соёлын төвийн зориулалттай барилга байгууламжид Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 11 сарын 24-ны өдрийн А/713 дугаар шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2020.07.17 /огноо/, БХ2020/41 /дугаар/
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЦЭ-13-01/19;
- 2.3. **Захиалагч;** Монгол Улсын Соёлын яам, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Соёлын яамны байр
Захиалагч: Баянхонгор аймаг, Баянлиг сумын ЗДТГ, Хаяг Баянхонгор аймаг, Баянлиг сум, Шинэ сум, ЗДТГ-ын байр
- 2.4. **Барилгын ажлын гүйцэтгэгч:** "Гал гэрэл констракшн" ХХК оноосон нэр, 9011650116 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, БУ12-494/17 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Рашаант 10-р баг, 118-р байр
- 2.6. **Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага:** "Цэсда" ХХК оноосон нэр, 321001002 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, ЗТ-49/17 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Шинэ төгөл хотхон
- 2.7. **Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:** Баянлиг сумын соёлын төв 000158506 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 8303231 Татвар

төлөгчийн дугаартай Хаяг: Баянхонгор аймаг, Баянлиг сум, Хатан суудал 5-р баг,
Шинэсум

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: 2 давхар, зорьгүй

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү бага төвөгшилтэй ангиллын 240 хүний суудалтай 2 давхар хүчин чадал бүхий Соёлын төвийн зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос

ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 2 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Бага төвөгшилтэй ангиллын 240 хүний суудалтай, 2 давхар хүчин чадал бүхий Соёлын төвийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

КОМИССЫН ДАРГА:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



С.ХҮРЭЛХУЯГ

АЗДТГАЗРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.НОРОВРИНЧИН

***Энэ дүрмийн дөрөвдүгээр хавсралтын хамт хүчинтэй.

----- оОо -----